

**ЗАХИАЛАГЧ
НАЛАЙХ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР**

**“НИЙТИЙН ЗОРИУЛАЛТТАЙ ОРОН СУУЦНЫ 67 ДУГААР БАЙРНЫ ГАДНА ХАНАНЫ
ДУЛААЛГЫН АЖИЛ /НД, 8 ДУГААР ХОРОО/” ҮНИЙН САНАЛ АВАХ БАРИМТ БИЧИГ**

Тендер шалгаруулалтын нэр: **Нийтийн зориулалттай орон сууцны 67 дугаар байрны
гадна хананы дулаалгын ажил /НД, 8 дугаар хороо/**

Тендерийн дугаар: **НХААГ/202003465**

Нэг. ҮНИЙН САНАЛ АВАХ УРИЛГА

Огноо : 2020 оны 03 дугаар сарын 23-ны өдөр

Налайх дүүргийн Худалдан авах ажиллагааны алба нь сонгогдсон эрх бүхий тендерт оролцогчдоос “Нийтийн зориулалттай орон сууцны 67 дугаар байрны гадна хананы дулаалгын ажил /НД, 8 дугаар хороо” гүйцэтгүүлэх тухай үнийн санал ирүүлэхийг урьж байна.

Үнийн санал ирүүлэх барааны техникийн тодорхойлолт болон холбогдох бусад материалыг хавсаргасан болно.

Үнийн саналыг **2020 оны 04 дүгээр сарын 01-ний өдрийн 10 цаг 00 минут-аас өмнө Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем (www.tender.gov.mn)-ээр ирүүлнэ.**

Үнийн саналыг нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан **2020 оны 04 дүгээр сарын 01-ний өдрийн 10 цаг 55 минут-д** нээнэ.

Тендер хүлээн авах этгээд: Тендерийн материалыг Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем (www.tender.gov.mn) хаягаар өөрийн аж ахуйн нэгжийн тоон гарын үсгийг ашиглан нэвтэрч цахим хэлбэр (pdf)-ээр илгээнэ.

Цахим тендер шалгаруулалт зохион байгуулах журмын дагуу тендерт оролцох хураамж **50.000** /тавин мянга/ төгрөгийг www.tender.gov.mn-ээр банкны цахим төлбөр тооцооны системийг ашиглан төлнө.

Дотоодын давуу эрх тооцох эсэх: **“Тооцно”**

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

**Налайх дүүрэг, 2 дугаар хороо, Хуульчдын гудамж,
Худалдан авах ажиллагааны алба. Утас:7023-2788**

Хоёр. ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА

- 1. Эрх бүхий тендерт оролцогч**
 - 1.1. Тендерт оролцогч нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйл буюу Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт /цаашид “ТШӨХ” гэх/-д заасан холбогдох шаардлагыг хангасан байна.
- 2. Тендер ирүүлэх, тендерийн нээлт**
 - 2.1. Захиалагч тендерүүдийг ТШӨХ-д заасан захиалагчийн хаягаар, ТШӨХ-д заасан огноо, цагаас өмнө хүлээн авна.
 - 2.2. Тендерийг ТШӨХ-д заасан хугацаанд, ТШӨХ-д заасан газар нээлтийг хийнэ.
 - 2.3. Тендерт оролцогч тендерийн материалд Хувь хүний нууцын тухай болон Байгууллагын нууцын тухай хуулиудаар ил болгохыг хориглосон мэдээллийг тусад нь хавтаслаж ирүүлнэ. Тус хавтасны эхэнд тэдгээр мэдээллийг нууцлах үндэслэлийг бичгээр тайлбарлаж, тендерт оролцогчийн итгэмжлэгдсэн этгээд гарын үсгээр баталгаажуулна. Эрх бүхий тендерт оролцогч болохыг нотлох ТШӨХ-д заасан баримт бичиг, тендерийн баримт бичигт заасан маягтуудыг нууцлахгүй ирүүлнэ.
- 3. Тендерийн иж бүрдэл**
 - 3.1. Тендерт оролцогчдод өгсөн зааварчилгааны дагуу бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ:
 - (а) Үнийн санал;
 - (б) Үнэлэгдсэн үе шатны ажлын хуваарь;
 - (в) Чадварын мэдээлэл /санхүүгийн тайлан, туршлагын мэдээлэл, гэрээ гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар/ болон бусад баримт бичиг;
 - (г) Шаардлагатай тусгай зөвшөөрөл;
 - (д) [Бэлтгэж ирүүлэх шаардлагатай бусад материалыг жагсаана.]
- 4. Тендерийн үнэ**
 - 4.1. Тендерийн үнэд тодорхойлсон нийт ажил хамрах ба тендерт оролцогчийн үнэлж ирүүлсэн үе шатны ажлын хуваарьт үндэслэнэ.
 - 4.2. Тендерт оролцогч үнийн хөнгөлөлтийг тендерт тусган санал болгож болно.
 - 4.3. Тендерт оролцогч нь зураг болон техникийн тодорхойлолтод тодорхойлогдсон ажлыг үнэлэхдээ үе шатны ажлын хуваарьт хураангуй байдлаар өгөгдсөн бүх нэр төрөлд нэгж үнэ болон нийт үнэ санал болгоно. Тендерт оролцогч аль нэг нэр төрлийн нэгж үнэ болон нийт үнийг бөглөөгүй орхисон тохиолдолд түүнийг гүйцэтгэсний төлбөрийг захиалагч хийхгүй ба бусад нэр төрлийн үнэд багтсан гэж үзнэ.
 - 4.4. Тендерт оролцогч нь тендер хүлээн авах эцсийн хугацаанаас 14 хоногийн өмнө хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль тогтоомжийн дагуу энэ гэрээ болон бусад үндэслэлээр гүйцэтгэгчийн төлөх ёстой бүх татвар, хураамж, бусад төлбөрийг тендерийн нийт үнэд багтаасан байна.
- 5. Үнийн саналын**
 - 5.1. Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш 30 хоногийн хугацаанд хүчинтэй байна.

**хүчинтэй
байх хугацаа**

- 6. Алдааг залруулах**
- 6.1. Захиалагч шаардлагад нийцсэн тендерийн арифметик алдааг шалгаж дараах байдлаар залруулна:
- (а) тоо болон үсгээр илэрхийлэгдсэн дүн хоорондоо зөрсөн бол үсгээр илэрхийлэгдсэндэйг зөв гэж үзнэ;
 - (б) үе шатны ажлын үнийн нийлбэр тендерийн маягтад заасан тендерийн нийт үнээс зөрвөл үе шатны ажлын үнийн нийлбэрийг үндэслэн тендерийн нийт үнийг залруулна;
 - (в) нэгж үнийг ажлын тоо хэмжээгээр үргүүлж гаргасан нэг мөр дэх нийт дүнд зөрүү гарвал нэгж үнийг давамгайлах гэж үзнэ. Гэхдээ захиалагчийн үзэж байгаагаар нэгж үнэд аравтын орны таслалыг андуурсан болох нь илэрхий байвал тухайн мөр дэх нийт дүнг зөв гэж үзэн холбогдох нэгж үнийг залруулна.
- 6.2. Захиалагчийн залруулсан тендерийн дүнг тендерт оролцогчийн зөвшөөрлөөр эцсийнх гэж үзнэ. Хэрэв тендерт оролцогч залруулсан дүнг хүлээн зөвшөөрөхгүй бол захиалагч түүний тендерээс татгалзана.
- 7. Санал болгосон үнэ, түүнийг үнэлэх**
- 7.1. Тендерт оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ.
- 7.2. Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангасан оролцогчдийн үнийг харьцуулж хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно.
- 8. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл**
- 8.1. Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгосныг түүний тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө утсан холбоогоор мэдэгдэж, албан бичгээр баталгаажуулна. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна.

Гурав. ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ

ТОӨЗ-НЫХОЛБОГОХ ЗААЛТ	Шалгуур үзүүлэлт
ТОӨЗ 1.1	<ul style="list-style-type: none"> - Хүчин төгөлдөр Улсын бүртгэлийн гэрчилгээ, тусгай зөвшөөрлийн гэрчилгээний эх хувиас хийсэн хуулбарыг нотариатаар баталгаажуулан ирүүлнэ. - Монгол Улсын, эсхүл үүсгэн байгуулагдсан улсын хуулийн дагуу татвар, хураамж, төлбөрөө тухайн тендер нээсэн өдрийн байдлаар бүрэн төлсөн байна. - Нийгмийн даатгалын байгууллагын тодорхойлолт; - Одоогийн ба сүүлийн 3 жилийн хугацаанд тендерт оролцогчийн оролцсон аливаа шүүхийн зарга, маргааны талаарх мэдээлэл: Шаардлагатай <p>Тухайн хуулийн этгээдийн байнгын үйл ажиллагаа явуулдаг орон нутгийн шүүхийн тодорхойлолтыг ирүүлэх /иргэн болон захиргааны хэргийн шүүхээс тус бүр авсан байна./</p> <p>Энэхүү тодорхойлолтоор Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.4 дэх хэсэгт заасан нөхцөл байдал илэрсэн тохиолдолд үнэлгээнд харгалзаж үзнэ.</p> <ul style="list-style-type: none"> - Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын тодорхойлолт. - Хугацаа хэтэрсэн зээл болон зээлийн хүүгийн өргүй тухай харилцагч банкны тодорхойлолтыг банк тус бүрээс ирүүлнэ. Дээрх тодорхойлолтуудыг тендер зарлагдсан өдрөөс хойш авсан байх ба тендер нээсэн өдрийн байдлаар хүчин төгөлдөр байна. - Тендерт оролцогчийг төлөөлөн гарын үсэг зурах этгээдийн итгэмжлэлийг маягтын дагуу нотариатаар баталгаажуулан ирүүлнэ. /Хэрвээ гүйцэтгэх захирлаас өөр албан тушаалтан гарын үсэг зурж байгаа бол шаардлагатай/ <p>Жич: Татвар, нийгмийн даатгал, банк, бусад байгууллагад хугацаа хэтэрсэн өр төлбөртэй, ял шийтгэлтэй болох нь холбогдо байгууллагуудаас ирүүлсэн тодорхойлолтоор нотлогдсон тохиолдолд тендерээс татгалзах үндэслэл болно.</p>
ТОӨЗ 2.1	<p>Тендер хүлээн авах хаяг, эцсийн хугацаа нь:</p> <p>Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем www.tender.gov.mn хаягаар өөрийн аж ахуйн нэгжийн тоон гарын үсэг ашиглан нэвтэрч цахим хэлбэр (pdf)-ээр илгээнэ.</p> <p>Цахим тендер шалгаруулалт зохион байгуулах журмын дагуу тендерт оролцох хураамж 50,000 /тавин мянга/ төгрөгийг www.tender.gov.mn-ээр банкны цахим төлбөр тооцооны системийг ашиглан төлнө.</p> <p>Огноо: 2020 оны 04 дүгээр сарын 01-ний өдөр</p> <p>Цаг: 10 цаг 00 минут</p> <p>Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем (www.tender.gov.mn)-ийн серверийн цагаар тооцогдох тул хугацаа хоцорсон тохиолдолд тендерийн материал хүлээн авах боломжгүй. Тендер хүлээн авах эцсийн хугацаа дуусахаас өмнө илгээсэн тендерийн материалаа буцаан засварлах, нэмэлт өөрчлөлт оруулах эрхтэй.</p>
ТОӨЗ 2.2	<p>Тендерийн нээлт хийх газар, хугацаа нь:</p> <p>Байгууллагын хаяг: Налайх дүүрэг, 2 дугаар хороо, Хуульчдын гудамж, Худалдан авах ажиллагааны алба.</p> <p>Давхар болон өрөөний дугаар: 2 дугаар давхар, Нээлтийн өрөө</p> <p>Огноо: 2020 оны 04 дүгээр сарын 01-ний өдөр</p> <p>Цаг: 10 цаг 55 минут</p>
ТОӨЗ 2.3	<p>Тендерт оролцогч тендерийн материалд Хувь хүний нууцын тухай болон Байгууллагын нууцын тухай хуулиудаар ил болгохыг хориглосон мэдээллийг тусад нь хавтаслаж ирүүлнэ. Тус хавтасны эхэнд тэдгээр мэдээллийг нууцлах үндэслэлийг бичгээр тайлбарлаж, тендерт оролцогчийн итгэмжлэгдсэн этгээд гарын үсгээр баталгаажуулна. Эрх бүхий тендерт оролцогч болохыг нотлох ТШӨХ-д заасан баримт бичиг, тендерийн баримт бичигт заасан маягтуудыг нууцлахгүй ирүүлнэ.</p>

ТОӨЗ 3.1 (а)	Маягтын дагуу үнийн саналыг баталгаажуулан ирүүлнэ.																																								
ТОӨЗ 3.1 (б)	Ажил гүйцэтгэх нарийвчилсан технологийн график гаргаж, төлөөлөх эрх бүхий этгээд баталгаажуулж ирүүлнэ. /14 хоногийн дотор ажил гүйцэтгэнэ./																																								
ТОӨЗ 3.1 (в)	<p>1. Санхүүгийн тайлан ирүүлэх жилийн тоо: Сүүлийн 2 жил буюу 2018, 2019 оны санхүүгийн тайлан.</p> <p>2. Борлуулалтын орлого: Сүүлийн 2 жил буюу 2018, 2019 оны дундаж 33.25 сая.төгрөгөөс багагүй байна.</p> <p>3. Ашигтай ажилласан жил: Сүүлийн 2 жил буюу 2018, 2019 онд хуримтлагдсан ашигтай ажилласан байна. Сангийн сайдын 2019 оны 255 дугаар тушаалаар батлагдсан “Худалдан авах ажиллагааны цахим системээр тендер шалгаруулалт зохион байгуулах, холбогдох мэдээллийг зарлан мэдээлэх журам”-ын 3.7-д заасны дагуу тендертээ санхүүгийн тайлан, татварын албаны тодорхойлолтыг ирүүлэх шаардлагагүй бөгөөд Татварын ерөнхий газрын татвар төлөгчдийн мэдээллийн сан, Сангийн яамны цахим санхүүгийн тайлангийн www.e-balance.mof.gov.mn-ээс тендерт оролцогчдын татвар төлөлт, санхүүгийн тайлангаас борлуулалтын орлого, хуримтлагдсан ашиг болон шаардлагатай мэдээллийг шалгана.</p> <p>4. Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ: 33.25 сая.төгрөгөөс багагүй байна. Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн нийт дүнг дараах шалгуур үзүүлэлтүүдийн аль нэгээр эсвэл [А] болон [Б] дахь заалтын нийлбэрээр тус тус тодорхойлно. Үүнд:</p> <p>А.Байгууллагын дансны үлдэгдэл /Харилцагч банкны/</p> <p>Б. Арилжааны банкны зээлийн авч болох мөнгөн дүн бүхий зээл авах баталгаажсан тодорхойлолт байна.</p> <p>В. Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн нийт дүнг Сангийн сайдын 2015 оны 343 дугаар тушаалаар батлагдсан “Санхүүгийн тайланда шинжилгээ хийх үлгэрчилсэн загвар”-ын 3.2.2 /е-/д “Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө = Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө + Санхүүгийн хөрөнгө + Дансны авлага гэсэн үзүүлэлтүүдээр дүгнэнэ” гэж заасны дагуу тодорхойлно.</p> <p>5. Ижил төстэй ажил гэрээгээр гүйцэтгэсэн туршлагын талаарх мэдээлэл ирүүлэх жилийн тоо: Сүүлийн 2 жил буюу 2018, 2019 онуудад хийж гүйцэтгэсэн барилгын засварын ажлын жагсаалтыг, ажил гүйцэтгэсэн гэрээ, акт, захиалагчийн тодорхойлолт хамт ирүүлнэ. 33.25 сая төгрөгөөс багагүй үнийн дүнтэй ижил төстэй ажил гүйцэтгэсэн байна.</p> <p>6. Тендерт оролцогч гэрээг гүйцэтгэхэд зайлшгүй шаардлагатай дараах үндсэн машин механизм, тоног төхөөрөмжүүдийг байлгах шаардлагатай:</p> <table border="1"> <thead> <tr> <th>№</th> <th>Машин механизм, тоног төхөөрөмжийн нэр</th> <th>Тоо</th> <th>Хүчин чадал</th> </tr> </thead> <tbody> <tr> <td>1.</td> <td>Цахилгаан өрөм</td> <td>1</td> <td></td> </tr> <tr> <td>2.</td> <td>Автокран</td> <td>1</td> <td>5 тн-оос багагүй</td> </tr> <tr> <td>3.</td> <td>Автомашин</td> <td>1</td> <td></td> </tr> <tr> <td>4.</td> <td>Дүүжин шат</td> <td>2</td> <td></td> </tr> <tr> <td>5.</td> <td>Гар миксер</td> <td>1</td> <td></td> </tr> <tr> <td>6.</td> <td>Теодилит</td> <td>1</td> <td></td> </tr> <tr> <td>7.</td> <td>Нивелир</td> <td>1</td> <td></td> </tr> <tr> <td>8.</td> <td>Лазер тэгш ус</td> <td>1</td> <td></td> </tr> <tr> <td>9.</td> <td>Рейк</td> <td>1</td> <td></td> </tr> </tbody> </table> <p>- Байгууллагын өөрийн эзэмшлийн машин механизм, багаж хэрэгсэл</p>	№	Машин механизм, тоног төхөөрөмжийн нэр	Тоо	Хүчин чадал	1.	Цахилгаан өрөм	1		2.	Автокран	1	5 тн-оос багагүй	3.	Автомашин	1		4.	Дүүжин шат	2		5.	Гар миксер	1		6.	Теодилит	1		7.	Нивелир	1		8.	Лазер тэгш ус	1		9.	Рейк	1	
№	Машин механизм, тоног төхөөрөмжийн нэр	Тоо	Хүчин чадал																																						
1.	Цахилгаан өрөм	1																																							
2.	Автокран	1	5 тн-оос багагүй																																						
3.	Автомашин	1																																							
4.	Дүүжин шат	2																																							
5.	Гар миксер	1																																							
6.	Теодилит	1																																							
7.	Нивелир	1																																							
8.	Лазер тэгш ус	1																																							
9.	Рейк	1																																							

	<p>нь тухайн байгууллагын нэр дээр байх ба фото зураг гэрчилгээний хуулбарыг ирүүлнэ.</p> <ul style="list-style-type: none"> - Түрээсээр ашиглах бол гэрчилгээний хуулбар, түрээсийн гэрээг эх хувиар хавсаргана. Мөн дээрх тоног төхөөрөмжүүдийг фото зургаар баталгаажуулан ирүүлнэ. - Хуулбар нь тод гаргацтай байна. Тээврийн хэрэгслийн гэрчилгээг нотариатаар гэрчлүүлэн ирүүлнэ. <p>7. Гэрээг хэрэгжүүлэх, удирдах болон техникийн голлох боловсон хүчний чадвар, туршлагын талаарх мэдээлэл: “Шаардлагатай” Дараах хүснэгтэд үзүүлсэн удирдах болон техникийн голлох боловсон хүчнийг ажиллуулна.</p> <table border="1"> <thead> <tr> <th>№</th><th>Албан тушаал</th><th>Хүний тоо</th><th>Мэргэжлээрээ ажилласан жилийн туршлага</th><th>Тухайн байгууллагад ажилласан жил</th><th>Мэргэжил</th></tr> </thead> <tbody> <tr> <td>1.</td><td>Барилгын инженер</td><td>1</td><td>3 болон түүнээс дээш жил</td><td rowspan="2">2019.02-2020.02 дугаар сарыг дуустал ажилласан байна.</td><td>Барилгын инженер</td></tr> <tr> <td>2.</td><td>Талбайн даамал</td><td>1</td><td>2 болон түүнээс дээш</td><td>Барилгын инженер</td></tr> <tr> <td>3.</td><td>Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн ажилтан</td><td>1</td><td>2 болон түүнээс дээш жил</td><td></td><td>/ХАБЭА сургалтанд хамрагдаж гэрчилгээ авсан байх/</td></tr> </tbody> </table> <p>Голлох боловсон хүчин нь тухайн байгууллагын үндсэн ажилтан байх бөгөөд сүүлийн 1 жилийн хугацаанд буюу 2019.02-2020.02 дугаар сарыг дуустал тухайн байгууллагад ажилласан байна. Тухайн голлох боловсон хүчний ажлын туршлагыг баталгаажулахын тулд нийгмийн даатгалын дэвтриний хуулбарыг ирүүлнэ./ Даатгуулагчийн ажил, албан тушаалын өөрчлөлтийн тэмдэглэл болон төлөлт хийгдсэн бичилттэй хэсгийг бүрэн хуулбарлан ирүүлнэ./ Голлох боловсон хүчний ТҮЦ машинаас авсан нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн 2019 оны тодорхойлолтыг ирүүлнэ.</p> <p>8. Тендерт оролцогч нь олон багц ажлын тендерт оролцох болон өөр барилга угсралтын ажил гүйцэтгэж байгаа бол зөвхөн тухайн төсөл, арга хэмжээнд ажиллуулах инженер техникийн ажилтан, машин механизмуудыг санал болгох бөгөөд давхацсан тохиолдолд татгалзах үндэслэл болно.</p> <p>9. Дотоодын давуу эрхийн зөрүү: “Тооцно”</p> <p>Тендерт оролцогч нь давуу эрх өдлэх хүсэлтэй бол албан хүсэлт, дэлгэрэнгүй нотлох баримтыг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйл, Сангийн сайдын 2018 оны 58 дугаар тушаалаар батлагдсан “Тендерт оролцогчдод давуу эрх олгох аргачлал”-ыг тус тус баримтлана.</p>	№	Албан тушаал	Хүний тоо	Мэргэжлээрээ ажилласан жилийн туршлага	Тухайн байгууллагад ажилласан жил	Мэргэжил	1.	Барилгын инженер	1	3 болон түүнээс дээш жил	2019.02-2020.02 дугаар сарыг дуустал ажилласан байна.	Барилгын инженер	2.	Талбайн даамал	1	2 болон түүнээс дээш	Барилгын инженер	3.	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн ажилтан	1	2 болон түүнээс дээш жил		/ХАБЭА сургалтанд хамрагдаж гэрчилгээ авсан байх/
№	Албан тушаал	Хүний тоо	Мэргэжлээрээ ажилласан жилийн туршлага	Тухайн байгууллагад ажилласан жил	Мэргэжил																			
1.	Барилгын инженер	1	3 болон түүнээс дээш жил	2019.02-2020.02 дугаар сарыг дуустал ажилласан байна.	Барилгын инженер																			
2.	Талбайн даамал	1	2 болон түүнээс дээш		Барилгын инженер																			
3.	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн ажилтан	1	2 болон түүнээс дээш жил		/ХАБЭА сургалтанд хамрагдаж гэрчилгээ авсан байх/																			
ТОӨЗ 3.1 (г)	Тендерт оролцогч тухайн ажилд шаардлагатай дараах тусгай зөвшөөрөлтэй байх шаардлагатай. Үүнд: Барилга, Хот байгуулалтын яамны БА-2.1. Цутгамал болон угсармал төмөр бетон, мод ба өрөгт бүтээцэн барилгын угсралт, өргөтгөл, шинэчлэлийн ажил тусгай зөвшөөрөл байх ба эсвэл үүнээс давсан нөхцлийг хангасан тусгай зөвшөөрөлтэй байх шаардлагатай.																							
ТОӨЗ 3.1 (д)	<ol style="list-style-type: none"> Ажлын талбайтай танилцсан тухай тэмдэглэл, фото зургийн хамт баталгаажуулан ирүүлнэ. Ажил гүйцэтгэх төсөв /Ажлын төсвийг ЗТБХБ-ын сайдын 2012 оны 181 дүгээр тушаалаар батлагдсан төсөв зохиох дүрэм, БХБ-ын сайдын 2015 оны 185 дугаар тушаалаар батлагдсан 																							

	<p>барилгын норм ба дүрэм шинэчлэн батласаны дагуу тооцож Монгол улсад хүчин төгөлдөр хэрэглэгдэж буй төсөв зохиох програмаар эрх бүхий төсөвчнөөр гүйцэтгүүлэн тэмдэг даруулан ирүүлэх шаардлагатай./</p>
ТОӨЗ 5.1	Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш 30 хоногийн хугацаанд хүчинтэй байна.

Дөрөв. ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ



2020 оны 03 дугаар сарын 16-ны өдөр

**НИЙТИЙН ЗОРИУЛАЛТТАЙ ОРОН СУУЦНЫ БАРИЛГЫН ГАДНА ХАНЫН ДУЛААЛГЫН
АЖЛЫН ДААЛГАВАР**

1	Үндэслэл	Нийслэлийн Засаг даргын 2020 оны 03 дугаар сарын 06-ны өдрийн А/315 дугаар захирамж
2	Барилга байршил	Налайх дүүрэг, 8 дугаар хороо
3	Барилга байгууламжийн зориулалт	Нийтийн зориулалттай орон сууцны 67 дугаар байр
4	Барилгын төрөл давхрын тоо	Угсармал 5 давхар
5	Ажлын тоо хэмжээ	1 байрны дулаалтын ажлын тоо хэмжээ: -Гадна хананд 1330.2m ² талбайд 100мм-ийн хөөсөнцөр полистрол хавтан, 69.4m ² талбайд 50мм-ийн хөөсөнцөр полистрол хавтангаар дулаалга хийх -Парпетний ус зайлцуулах цайрдсан төмөр /40см өргөн/- 36.68m ² -Цонхны ус зайлцуулах цайрдсан төмөр /25см өргөн/- 33.95m ² -Цокольд 5.04m ² шавар нөхөөс хийж, 100.88m ² талбайд өнгийн тосон будгаар будах
6	Гадна заслын ажил	Орон сууцны барилгын гадна ханыг сайтар цэвэрлэн илүү гарсан шавар болон бусад зүйлийг хусаж тэгшлэх, шавардах, элс цементэн зуурмагаар тэгшлэх арга хэмжээ авч цавууны хөрсжүүлэлт хийнэ. 1 дүгээр давхрын бүх өндөрөөр буюу барилгын булангудад, цонх хаалганы орчимд 3-4мм зузаан цавуут зуурмаг түрхлэгтэй MNS EN 13164:2011 Барилгын дулаан тусгаарлах материал хөөсөн шахмал полистирол (XPS) бүтээгдэхүүний техникийн шаардлагын стандартад нийцсэн 30kg/m ³ 50мм-ийн зузаантай хөөсөн шахмал полистирол материалаар 2үе ам даруулан нааж, тэлэгчтэй дюбель хадаасаар ирмэгээс нь 10см дотор, хадаас хоорондын зайд 40см Т хэлбэрээр бэхжлж тогтооно. Бусад давхруудад 3-4мм зузаан цавуут зуурмаг түрхлэгтэй MNS EN 13164:2011 Барилгын дулаан тусгаарлах материал хөөсөн шахмал полистирол (XPS) бүтээгдэхүүний техникийн шаардлагын стандартад нийцсэн 25kg/m ³ 50мм-ийн зузаантай хөөсөн шахмал полистирол материалаар 2үе ам даруулан нааж, тэлэгчтэй дюбель хадаасаар ирмэгээс нь 10см дотор, хадаас хоорондын зайд 40см Т хэлбэрээр бэхжлж тогтооно. /Ханын зах хэсэгт дулаалгын хавтанг илүү тэлэгчтэй хадаасаар тогтооно/

		<p>Хаалга, цонхны уулзвар хэсэгт дулаалгын материалыг нэг шулуунд бус ам даруулж дулааны урсгалыг хааж угсарна.</p> <p>Цокол хэсэгт дулаалгын зузаантай ижил хэмжээний тулгуур тэмрийг 1м-ийн зйтай хадасаар тэгш бэхлэнэ. Тэгш бус гадаргуутай үед хуванцар жийрэг буюу тэгшлэгч хийж өгнэ.</p> <p>Хөөсөн шахмал полистрол хавтан дээр полиропилен (хуванцар матерериал) тор бүхий цавуут зуурмагийг 10см зөрүүлэн хийнэ. Хаалга, цонхны ирмэгт нэмэлт булан торуудыг хийнэ. Тор нааж цавууг хатсаны дараа хөрсжүүлэгч хийж өнгөлгөөний шавардлага, зориулалтын фасадны эмульс будгаар өнгө гаргаж будна.</p> <p>Дээврийн парпет болон цонхны ус зайлцуулах цайдсан тэмрийг шинээр сольж хийх ба гүйцэтгэх явцад парпет хэсгийн агаарын үеийг таглахгүй байх.</p> <p>Гадна ханын загварыг ажлын даалгаварын хавсралтад зааснаар гүйцэтгэнэ.</p> <p>Барилгын гадна ханын хаяг дугаар болон орцын дугаарыг тусгай фосфортдог материалаар хийнэ. Байгалийн ба зохиомол гэрэлтүүлэг БНБД 23-02-08, Орон сууц олон нийтийн барилгын гэрэлтүүлэг БНБД 81-20-04 норм ба дүрэмд нийцүүлэн парпетнаас 80см-ийн доор ханын гадаргууг хөдлөн уртаар тойруулан 92.52м урт лед туузан гэрэлтүүлэг хийх, гэрэлтүүлгийн цахилгааны холболтыг гүйцэтгэхдээ "УБЦТС" ТӨХК-ий Налайх хэрэглэгчдэд үйлчлэх төвд мэдэгдэх.</p>
7	Аюулгүй байдал	<p>Барилга байгууламж барих, ашиглах үеийн галын аюулгүй байдлыг хангаж, барилгын бүтээцэд галд тэсвэршилтэй материал ашиглах, гал унтраах хэрэгслийг тусгах</p> <p>Барилгын ажлын аюулгүй ажиллагааны журмыг мөрдөх</p>
8	Гүйцэтгэгч	"Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил, үйлчилгээ худалдан авах тухай" хуулиар
9	Ажил эхлэх	Засварын ажлыг гүйцэтгэхийн өмнө Налайх хотын Захиргачийн Ажлын алба болон харьяа сууц өмчлөгчдийн холбооны удирдлагатай зөвшүүлсөний дунд ажил эхлэх.
10	Хэрэгжүүлэх хугацаа	Захиалагч болон гүйцэтгэгчийн байгуулсан ажил гүйцэтгэх гэрээг үндэслэнэ.
11	Ажил гүйцэтгэх	<p>Барилгын үйл ажиллагаанд оролцогч байгууллагуудын барилгын техникийн дотоод хяналтын жишиг дүрмийн мөрдөх</p> <p>Барилгын гадна ханын шавардлагатай дулаан тусгаарлалтын ажлын техникийн дүрэм БД 12-103-07</p> <p>Барилга, замын ажил гүйцэтгэхдээ иргэдийн аюулгүй байдлыг хангах ерөнхий шаардлага UCS0001-01:2019</p>

Ажлын зохион байгуулалт, түүнд тавигдах шаардлагууд:

- Ажлыг гүйцэтгэж байх явцад технологийн үе шат бүрд гүйцэтгэсэн ажлыг шалгувж, техникийн шаардлага бүрэн хангагдсан гэж үзвэл ил, далд ажлын акт, гүйцэтгэлийн зураг хийж дараагийн үе шатны ажлыг гүйцэтгэнэ.
- Талбайн ажлыг хийж гүйцэтгэхдээ бусад ажилтай уялдуулан, тухайн байршилд ажил үйлчилгээ явуулж буй аж ахуйн нэгж байгууллагуудын ажил үйлчилгээ болон оршин суугчдын ая тухтай, аюулгүй зорчиход ямар нэгэн саад бэрхшээл учруулахгүй ажиллах нөхцлийг бүрдүүлэн талбайн зохион байгуулалтыг хийж ажиллах шаардлагатай.
- Ажил гүйцэтгэх явцад талбайд ажиллах буй ажилчдад хөдөлмөр хамгаалалт аюулгүй ажиллагааны зааварчилгааг тогтмол өгч ажиллана.
- Заслын нимгэн үетэй гадна ханын дулаан тусгаарлалтын угсралтыг барилгын угсармал тэмэр шат ашиглаж хийнэ. Барилгын дүүжин шат хэрэглэх, дулаалгын хавтанг хананд бэхэлсний дараагаар арматурчалын үеийг хийлгүйгээр удаан хугацаагаар угсралтын ажлыг зогсоох, хөөснөнцөр полистрол хавтангийн гадаргууд хамгаалалтын үе хийгээгүй үед гагнуурын ажил гүйцэтгэхгүй байх.
- Барилгын гадна талын дулаан тусгаарлалтын ажлыг орчны хэм +5С-аас бага, +27С-аас их болон ханын гадаргууд хур тунадасын чийг унах үеэр зогсоо.
- Дээврийн хамгаалах үегүй буюу барилгын нүүр тал ба шатыг хур тунадасаас хамгаалах хаалт хийгээгүй тохиолдолд бороо орж байхад болон борооны дараа дээврийн гадаргуу чийгтэй байхад, салхины хурд 10м/с-ээс дээш байх үед дулаалгын ажил хийхийг хориглоно.
- Гэрээнд тусгагдсан бүх ажлыг Монгол улсад мөрдөгдөж буй хууль тогтоомж, БНБД, стандартын дагуу хийж гүйцэтгэнэ.
- Гэрээнд заасан ажлыг гүйцэтгэхдээ талбайн зохион байгуулалтыг хийж шаардлагатай.

Захиалагчийн хяналт:

- Гадна дулаалгын ажлын даалгаварын хэрэгжилтэд
- Угсралтын ажлын явцад гарах тесөвтэй холбоотой асуудлыг зохих шатны албан тушаалтантай хамтран шийдвэрлүүлэх.

Гүйцэтгэгч байгуулага:

- Гүйцэтгэгч байгууллага нь ажлын тоо хэмжээний дагуу чанарын өндөр түвшинд, гэрээний хугацаанд багтаан гүйцэтгэх.
- Ажлын талбай дээр ажлыг гүйцэтгэж эхлэхээс өмнө тухайн орон сууцны СӨХ-ны удирдлагад ажил эхэлж байгааг мэдэгдэж, анхааруулах тэмдэг, хамгаалах тор татах оршин суугчид болон иргэдийн аюулгүй байдлыг хангаж, гэнэтийн осол гаргахгүй байх ажлыг зохион байгуулна.
- Ажлын талбайд журнал байнга байлгаж, хяналтын инженерүүдийн өгсөн үүрэг даалгавар, шаардлага, дүгнэлтийн биелэлтийг гаргана.
- Гүйцэтгэгч нь импортын материал ашиглах нөхцөлд гарал үүсэл, тохирлын гэрчилгээ, сертификат, лабораторийн шинжилгээний дүнг хавсарган баталгаат орчуулга хийлгэсэн байх. Үндэсний үйлдвэрийн материалыг ашиглах нөхцөлд “Бүтээгдэхүүний тохирлын гэрчилгээ” лабораторийн шинжилгээний дүнг хавсаргаж ирүүлнэ.
- Дулаалгын ажилд ашиглагдах материалыг зураг, тесөлд тусгагдаагүй болон захиалагчтай тохиролцолгүйгээр өөр материалыаар орлуулахыг хориглоно.
- Үе шатны ажил бүрт ил, далд ажлын акт, схем, фото зургаар баталгаажуулсан байна.


- Чанаргүй хийсэн ажлыг өөрийн хөрөнгөөр захиалагчийн заасан хугацаанд засварлах.
- Барилгын талбайгаас гарах хаягдлыг зайлцуулахдаа “Тохижилт үйлчилгээ” ОНӨААТҮГ-тай хог тээврийн гэрээ байгуулан зөвшөөргдсөн хогийн цэгт хог хаягдлыг хаях.

Засварын ажлын материалд тавигдах шаардлага:

- Засварын ажилд ашиглагдах материал нь галд тэсвэртэй, шаталтыг дэмждэггүй байна.
- Ажлыг чанарын өндөр түвшинд гүйцэтгэнэ.

Дээрх техникийн тодорхойлолтод заасан шаардлагыг биелүүлээгүй нөхцөлд захиалагчийн төлөвлөгч, мэргэжлийн хяналтын улсын байцаагч нар эрхийнхээ дагуу ажлыг тодорхой хугацаагаар зогсоох хүртэл арга хэмжээ авах зорилттай.


Боловсруулсан: Захирагчийн Ажлын албаны
Хот төлөвлөлт, барилга байгууламж, сууц
өмчлөгчдийн холбоо хариуцсан мэргэжилтэн



Б.Галмэнх

Тав. ЗУРАГ

НИЙТИЙН ЗОРИУЛАЛТТАЙ ОРОН СУЦНЫ БАРИЛГЫН ГАДНА ХАНЫН
ДУЛААЛГЫН АЖЛЫН ДААЛГАВРЫН ХАВСРАЛТ

M1:100





Зургаа. ҮЕ ШАТНЫ АЖЛЫН ХУВААРЬ

Үе шатны ажлын хуваарь бэлтгэх санамж

Зорилт

Үе шатны ажлын хуваарийг дараах зорилгоор бэлтгэдэг. Үүнд:

(а) гэрээний дагуу гүйцэтгэх ажлын тоо хэмжээний талаар хангалттай мэдээллийг гаргаж тендерийг зохих ёсоор, нягт нямбай бэлтгэх бололцоог олгох;

(б) гэрээ байгуулсны дараа ажлын гүйцэтгэлийг тооцож үнэлэхэд үе шатны ажлын хуваарыт заасан үнийг үндэслэх.

Эдгээр зорилтыг хэрэгжүүлэхийн тулд үе шатны ажлын хуваарыт хоорондоо ялгаатай ажлуудын, эсхүл өөр өөр газар гүйцэтгэх ижил төстэй ажлын ялгааг гаргаж өгөх, эсхүл өргтийг ялгаатайгаар авч үзэх нөхцөлийг харгалзах зорилгоор үе шатны ажлын хуваарийг зохих нэр төрлөөр нь задлах хэрэгтэй. Эдгээр шаардлагатай нийцүүлэн үе шатны ажлын хуваарийн агуулга аль болохоор энгийн бөгөөд товч байх ёстой. Гадна тохижилтын ажил болон нөхөн сэргээх зардлыг үе шатны ажлын хуваарыт заавал оруулна.

Ажил-өдрийн хуваарь

Ажил-өдрийн хуваарийг үе шатны ажлын хуваарийн нэр төрөлд тусгагдаагүй магадлашгүй ажил гарах магадлал өндөр бол оруулна. Тендерт оролцогчийн ирүүлсэн нэгж үнэ бодитой эсэхийг шалгах боломжийг захиалагчид олгох зорилгоор ажил-өдрийн хуваарь нь ихэвчлэн дараах зүйлээс бүрдэнэ:

(а) тендерт оролцогч ажил-өдрийн нийт үнийг бөглөж ирүүлэх ажиллах хүч, материал, барилга байгууламжийн нэр төрлийн жагсаалт. Мөн ажил-өдрийн хэлбэрээр гүйцэтгэсэн ажилд төлбөр хийх нөхцөлийн талаарх мэдээлэл.

(б) тендерт оролцогч бүрийн нэгж үнээр үнэлж ирүүлэх ажил-өдрийн нэр төрлийн тоо хэмжээ. Тендерт оролцогчийн ажил-өдрийн нэр төрөлд санал болгох нэгж үнэ нь гүйцэтгэгчийн ашиг, захиргааны, хяналтын болон бусад зардлыг багтаасан байна.

Магадлашгүй зардал

Магадлашгүй ажлын зардалд зориулсан тодорхой мөнгөн дүнг үе шатны ажлын хуваарыт заах замаар магадлашгүй ажлын зардлын талаар ерөнхий заалт оруулж болно. Мөн үнийн өсөлтөд зориулсан тодорхой дүнг магадлашгүй зардал хэлбэрээр үе шатны ажлын хуваарыт зааж болно. Магадлашгүй зардлыг гэрээнд тусгах нь ирээдүйд шаардлага гарсан үед нэмэлт төсөв хуваарилуулж батлуулах ажиллагаанаас зайлсхийх бололцоо олгоно. Магадлашгүй зардлыг хэрэглэсэн үед гэрээний тусгай нөхцөлд тэдгээрийг хэний зөвшөөрлөөр (ихэвчлэн төслийн менежерийн) хэрхэн хэрэглэх аргыг заана.

Үе шатны ажлын хуваарь бэлтгэхэд зориулсан энэ санамж нь зөвхөн захиалагч болон тендерийн баримт бичгийг боловсруулж буй хүмүүст зориулагдсан болно. Эдгээрийг эцсийн баримт бичигт оруулахгүй.

Долоо. ЖИШИГ МАЯГТ

ҮНИЙН САНАЛЫН МАЯГТ

[огноо]

(Захиалагч байгууллагын нэр)-ын дарга _____ танаа

- Бид, [тендерт оролцогчийн нэр], [гэрээний нэр ба дугаар]-ыг [тендерийн үнийг тоогоор болон үсгээр] төгрөгөөр тендерийн баримт бичгийн дагуу гүйцэтгэхээр санал болгож байна.
- Тендер нь тендерийн баримт бичигт заасны дагуу тендер хүлээн авах эцсийн хугацаанаас хойш **30** хоногийн хугацаанд хүчинтэй байх ба та энэ хугацаа дуусахаас өмнө түүнийг сонгох боломжтой.
- Гэрээг албан ёсоор байгуулах хүртэл энэхүү тендер болон түүнийг шалгарсан тохиолдолд гэрээ байгуулах эрх олгох мэдэгдэл нь бидний хооронд хийгдсэн хэлцэл болно.
- Бид гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч байна гэдгийг үүгээр батламжилж байна.
- Бид тендерийг холбогдох журмын дагуу бусад тендерт оролцогчдод ил болгохыг үүгээр зөвшөөрч байна. Захиалагч бидний ирүүлсэн тендерийг нууцлах аливаа үүргээс бүрэн чөлөөлөгднө.

Тендерт оролцогчийн нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг:

Найм. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

- | | |
|--|---|
| <p>1. Гүйцэтгэгч ажил гүйцэтгэх</p> <p>2. Төслийн менежерийн шийдвэр</p> <p>3. Ажил дуусгахаар төлөвлөсөн өдөр ажил дууссан байх</p> <p>4. Аюулгүй байдал</p> <p>5. Зааварчилга а</p> <p>6. Маргааныг шийдвэрлэх</p> <p>7. Ажлын хөтөлбөр</p> <p>8. Зөрчил, гологдол илрүүлэх</p> <p>9. Зөрчил, гологдол арилгах</p> | <p>1.1. Гүйцэтгэгч гэрээний тусгай нөхцөлд заасан ажлыг техникийн тодорхойлолт болон зургийн дагуу хийж гүйцэтгэнэ.</p> <p>2.1. Гэрээнд тусгайллан заагаагүй бол гэрээтэй холбогдсон аливаа асуудлыг захиалагчийг төлөөлөн төслийн менежер шийдвэрлэнэ.</p> <p>3.1. Гүйцэтгэгч ажлыг гэрээний тусгай нөхцөлд заасан өдөр эхлүүлж, өөрийн гаргасан ажлын хөтөлбөр болон төслийн менежерийн баталсан тодотгосон ажлын хөтөлбөрийн дагуу хийж гүйцэтгэн, ажил дуусгахаар төлөвлөсөн өдөр дуусгана.</p> <p>4.1. Гүйцэтгэгч ажлын талбай дээрх бүх үйл ажиллагааны аюулгүй ажиллагааг хангаж ажиллана.</p> <p>4.2. Барьж байгаа барилга, байгууламжаа байгалийн болзошгүй гамшиг, гэнэтийн аюулаас хамгаалах бүх талын арга хэмжээг авч, өөрийн нь ажилтай холбогдуулж барилгын болон байгаль орчин, эрүүл ахуй, гал түймрийн хяналтын албанаас гаргасан хууль ёсны шаардлага, дүгнэлтийг хүлээн авч биелүүлнэ.</p> <p>5.1. Төслийн менежерийн гаргах аливаа зааварчилгаа нь Монгол улсын хууль, тогтоомжид нийцсэн байх бөгөөд түүнийг гүйцэтгэгч биелүүлэх үүрэгтэй</p> <p>6.1. Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргана.</p> <p>7.1. Гүйцэтгэгч нь ажил гүйцэтгэхдэд шаардлагатай бүх үйл ажиллагааны ерөнхий аргачлал, зохион байгуулалт, дэс дараалал, ажил гүйцэтгэх хугацаа болон бусад шаардлагатай мэдээллийг тусгасан ажлын хөтөлбөрийг боловсруулж, гэрээний тусгай нөхцөлд заасан хугацаанд төслийн менежерт хүргүүлж батлуулна.</p> <p>7.2. Ажлын хөтөлбөрийг төслийн менежер батлах нь гүйцэтгэгчийн үүрэг хариуцлагыг хөндөхгүй. Гүйцэтгэгч нь ажлын хөтөлбөрийг хянан засварлаад төслийн менежерт хэдийд ч дахин хүргүүлж болно. Хянан засварласан ажлын хөтөлбөрт өөрчлөлтийг тусгана.</p> <p>8.1. Төслийн менежер гүйцэтгэгчийн ажлыг шалгаж, илэрсэн зөрчил, гологдолын талаар түүнд мэдэгдэнэ. Энэхүү шалгалт нь гүйцэтгэгчийн үүрэг хариуцлагыг хөндөхгүй. Төслийн менежер зөрчил, гологдол байж болзошгүй гэж үзсэн аливаа ажилд зөрчил, гологдол хайх, уг ажлын далд хэсгийг нээж шалгалт, туршилт явуулах талаар зааварчилгааг гүйцэтгэгчид өгөх эрхтэй.</p> <p>9.1. Төслийн менежер гэрээний тусгай нөхцөлд заасан чанарын баталгаат хугацаа¹ дуусхаас өмнө зөрчил, гологдол арилгах тухай мэдэгдлийг гүйцэтгэгчид өгнө. Чанарын баталгаат хугацааг зөрчил, гологдолыг арилгаж дуусах хүртэл сунгана.</p> <p>9.2. Зөрчил, гологдол арилгах тухай мэдэгдэл өгсөн тухай бүр гүйцэтгэгч уг зөрчил, гологдолыг төслийн менежерийн мэдэгдэлд</p> |
|--|---|

¹ Чанарын баталгаат хугацааг тогтоохдоо Иргэний хууль болон Барилгын тухай хуулийг баримтална.

	заасан хугацаанд багтааж өөрийн зардлаар арилгана.
10. Зөрчил, гологдол арилгахгүй байх	10.1. Хэрэв гүйцэтгэгч зөрчил, гологдлыг төслийн менежерийн мэдэгдэлд заасан хугацаанд багтааж арилгаагүй бол төслийн менежер зөрчил, гологдол арилгахад шаардагдах зардлыг тооцож гүйцэтгэгчээс гаргуулна.
	В. ЗАРДЛЫН ХЯНАЛТ
11. Үе шатны ажлын хуваарь	11.1. Төслийн менежерийн шаардсаны дагуу гүйцэтгэгч үе шатны ажлын тодотгосон хуваарийг 14 хоногийн дотор бэлтгэж ирүүлнэ. Үе шатны ажлын хуваарь тусгагдсан үйл ажиллагаа нь ажлын хөтөлбөрт тусгагдсан үйл ажиллагаатай нийцсэн байна.
12. Үе шатны ажлын хуваарийг өөрчлөх	11.2. Ажлын талбай дахь материалын төлбөрийг тусад нь хийх бол гүйцэтгэгч ажлын талбайд нийлүүлсэн материалын тооцоог үе шатны ажлын хуваариас тусад нь гаргаж ирүүлнэ.
13. Алданги	12.1. Гүйцэтгэгчийн шийдвэрээр ажлын арга барил, эсхүл ажлын хөтөлбөрт гарсан өөрчлөлтийг тусгах зорилгоор гүйцэтгэгч үе шатны ажлын хуваарь нэмэлт өөрчлөлт хийнэ. Өөрчлөлт хийхдээ үе шатны ажлын хуваарь дахь үнийг өөрчлөхгүй.
	13.1. Гүйцэтгэгч нь ажил дуусгахаар төлөвлөсөн өдрөөс хугацаа хоцорсон хоног тутамд гэрээний тусгай нөхцөлд заасан хувь хэмжээгээр алданги ² төлнө. Алдангийн нийт дүн гэрээний тусгай нөхцөлд заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй. Захиалагч нь алдангийг гүйцэтгэгчид төлөх төлбөрөөс сүүтган авч болно. Алданги төлсөн нь гүйцэтгэгчийн хүлээсэн үүрэг хариуцлагыг хөндөхгүй.
	Г. ГЭРЭЭГ ДУУСГАХ
14. Ажил дуусгах	14.1. Гүйцэтгэгч нь ажил дууссан тухай мэдэгдэл гаргах хүсэлтийг төслийн менежерт тавих бөгөөд төслийн менежер ажил дууссан гэж үзвэл уг мэдэгдлийг гаргана. Гүйцэтгэгч гадна тохижилтын ажлыг бүрэн дуусгаж, ажлын явцад гудамж, зам, талбай сэтэлж, мод, цэцэрлэгжүүлэлтийг түр зайлцуулсан бол эдгээрийг бүрэн хэмжээгээр сэргээсэн байна.
15. Хүлээж авах	15.1. Төслийн менежер ажил дууссан тухай мэдэгдэл гаргаснаас хойш захиалагч долоо хоногийн дотор ажлын талбай болон ажлыг хүлээж авна.
16. Эцсийн тооцоо	16.1. Гүйцэтгэгч гэрээний дагуу төлөгдөх ёстой гэж үзэж буй нийт төлбөрийн нарийвчилсан тооцоог гаргаж, чанарын баталгаат хугацаа дуусгахаас өмнө төслийн менежерт хүргүүлнэ. Төслийн менежер зөрчил, гологдол арилгасан тухай мэдэгдэл гаргаж, хэрэв гүйцэтгэгчийн ирүүлсэн тооцоо бүрэн гүйцэд, үнэн зөв бол уг тооцоог хүлээн авснаас хойш 14 хоногийн дотор гүйцэтгэгчид төлөх эцсийн төлбөрийг тодорхойлно. Хэрэв тооцоо буруу байвал шаардлагатай запруулга, нэмэлт өөрчлөлтийн талаарх тайлбарыг 14 хоногийн дотор гаргаж гүйцэтгэгчид хүргүүлнэ. Хэрэв засвар хийж дахин ирүүлсэн эцсийн тооцоо нь шаардлага хангагүй бол төслийн менежер гүйцэтгэгчид төлөх дүнг шийдвэрлэж төлбөрийн мэдэгдэл гаргана.

² Алдангийг ихэвчлэн хоногт 0.05-0.10 хувиар тогтоох бөгөөд нийт дүн нь гэрээний үнийн 5-10%-иас хэтрэх ёсгүй.

- 17. Ашиглалт, засвар, үйлчилгээний гарын авлага**
- 17.1. Гүйцэтгэгч ажлын гүйцэтгэлийн зураг, далдлагдсан ажил, инженерийн шугам сүлжээ, технологийн тоног төхөөрөмжийг туршиж тохируулсан акт болон захиалагч шаардсан бол ашиглалт, засвар үйлчилгээний гарын авлагыг гэрээний тусгай нөхцөлд заасан хугацаанд хүлээлгэн өгнө.
- 17.2. Хэрэв гүйцэтгэгч 22.1-д заасан материалыг гэрээний тусгай нөхцөлд заасан хугацаанд ирүүлээгүй, эсхүл шаардлага хангаагүйн улмаас тэдгээрийг төслийн менежер батлаагүй бол гүйцэтгэгчид төлөх ёстой төлбөрөөс төслийн менежер гэрээний тусгай нөхцөлд заасан үнийн дүнг суутгана.
- 18. Гэрээг цуцлах**
- 18.1. Захиалагч, эсхүл гүйцэтгэгч нөгөө тал нь гэрээг ноцтой зөрчсөн гэж үзвэл гэрээг цуцлах эрхтэй.
- 18.2. Дор дурдсан нөхцөлүүдийг гэрээний ноцтой зөрчил гэж үзэх бөгөөд эдгээрээр хязгаарлагдахгүй:
- (а) ажлын хөтөлбөрт ажил зогсоох тухай заагаагүй, түүнчлэн ажил зогсоох тухай шийдвэрийг төслийн менежер батлаагүй байхад гүйцэтгэгч ажлыг 28 буюу түүнээс дээш хоногийн хугацаагаа зогсоосон;
 - (б) төслийн менежер ажлын явцыг зогсоох зааварчилгааг гүйцэтгэгчид өгсөн бөгөөд уг шийдвэрээ 28 хоногийн дотор цуцлаагүй;
 - (в) захиалагч, эсхүл гүйцэтгэгч дампуурсан, эсхүл өөрчлөн байгуулагдах, нэгдэхээс бусад зорилгоор татан буугдсан;
 - (г) тодорхой зөрчил, гологдлыг арилгаж чадаагүй нь гэрээний ноцтой зөрчил болохыг төслийн менежер гүйцэтгэгчид мэдэгдсэн бөгөөд гүйцэтгэгч нь уг зөрчил, гологдлыг заасан хугацаанд нь багтаан арилгаж чадаагүй;
 - (д) гүйцэтгэгч ажлын гүйцэтгэлийг гэрээний тусгай нөхцөлд заасан алдангийн дээд хэмжээ төлөх хугацаагаар хоцроосон.
- 18.3. Гэрээг цуцалсан тохиолдолд гүйцэтгэгч ажлыг даруй зогсоож, ажлын талбайн бүрэн бүтэн, аюулгүй байдлыг хангаж, түүнийг аль болох түргэн хугацаанд чөлөөлнө.
- 19. Гэрээг цуцалсан үед хийх төлбөр**
- 19.1. Гүйцэтгэгч гэрээг ноцтой зөрчсөний улмаас гэрээ цуцлагдсан бол төслийн менежер гүйцэтгэсэн ажлын болон захиалсан материалын үнэлгээг нотолсон мэдэгдэл гаргана. Ингэхдээ мэдэгдэл олгосон өдөр хүртэл дуусаагүй ажлын гэрээний тусгай нөхцөлд заасан хэмжээг дээрх үнэлгээнээс хасна. Нэмэлт алданги гүйцэтгэгчид ногдуулахгүй.
- 19.2. Гэрээг захиалагчийн шаардлагаар, эсхүл гэрээг захиалагч ноцтой зөрчсөний улмаас цуцалсан бол гүйцэтгэсэн ажлын болон захиалсан материалын үнэлгээ, тоног төхөөрөмжийг ажлын талбайгаас гаргах бодит зардал, ажлын зорилгоор хөлслөн ажиллуулсан гүйцэтгэгчийн ажилтнуудыг буцаахтай холбогдсон зардал, түүнчлэн ажлыг хадгалах, хамгаалахтай холбогдсон зардал зэрэг гүйцэтгэгчийн зардлыг төслийн менежер хянаж мэдэгдэл гаргана.
- 20. Гүйцэтгэлээс чөлөөлөх**
- 20.1. Гэнэтийн болон давагдашгүй хүчний нөхцөл байдлын улмаас гэрээг гүйцэтгэх боломжгүй болсон бол төслийн менежер үүнийг

гэрчилнэ. Гүйцэтгэгч нь энэхүү мэдэгдлийг хүлээн авсны дараа ажлын талбайн бүрэн бүтэн байдлыг хангаж, ажлыг аль болох богино хугацаанд зогсоно. Захиалагч уг мэдэгдэл гарахаас өмнө хийгдсэн ажил болон түүний дараа захиалгаар гүйцэтгэсэн ажлын хөлсийг гүйцэтгэгчид төлнө.

Ес. ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

ГЕН 2.1	Гэрээний нэр болон бүртгэлийн дугаар: <i>Нийтийн зориулалттай орон сууцны 33 дугаар байрны гадна хананы дулаалгын ажил /НД, 2 дугаар хороо/ НХААГ/202003466</i>
ГЕН 2.1	Ажил нь <i>Налайх дүүргийн 2 дугаар хорооны орон сууцны 33 дугаар байрны гадна ханын дулаалгын ажлаас бүрдэнэ.</i> Ажлын талбай нь: <i>Налайх дүүргийн 2 дугаар хорооны 33 дугаар байр.</i>
ГЕН 3.1	Төслийн менежер нь <i>Нийслэлийн Налайх дүүргийн Засаг даргын Тамгын газрын дарга Ж.Алтангэрэл</i>
ГЕН 4.1	Ажил эхлэх өдөр: <i>Гэрээ байгуулсан өдрөөс эхэлнэ.</i> Ажил дуусгахаар төлөвлөсөн өдөр: <i>14 хоногийн дотор гүйцэтгэнэ.</i>
ГЕН 7.1	Гүйцэтгэгч гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдлийг хүлээн авснаас хойш 14 хоногийн дотор тодотгосон ажлын хөтөлбөрийг гаргана.
ГЕН 9.1	Чанарын баталгаат хугацаа 3 жил байна.
ГЕН 13.1	Алданги ноогдуулах хэмжээ: Алданги ногдуулах хэмжээ хоногт гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0,5 хувь байна. Нийт ажилд ногдуулах алдангийн дээд хэмжээ нь гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 50 хувь байна
ГЕН 17.1	Ашиглалт, засвар үйлчилгээний гарын авлагыг 3 хоногийн дотор гаргаж өгнө.

ГЭРЭЭНИЙ МАЯГТ

ЗАХИАЛАГЧ

ГҮЙЦЭТГЭГЧ

(Тамга, тэмдэг)	(Тамга, тэмдэг)
(Гарын үсэг)	(Гарын үсэг)
(Албан тушаал)	(Албан тушаал)

[Тендер шалгаруулалт/гэрээний нэр] гэрээ.

Дугаар № [Тендер шалгаруулалт/гэрээний дугаар]

..... хот/аймаг

Нэг талаас [захиалагчийн нэр] (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас [гүйцэтгэгчийн хот, улс, гүйцэтгэгчийн нэр] (цаашид “гүйцэтгэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож _____ оны _____ сарын _____ -ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний хууль, Барилгын тухай хууль болон бусад хууль тогтоомжийн дагуу инженерийн хийцтэй барилга байгууламж барих, засварын ажил гүйцэтгэх, тоног төхөөрөмж сууринуулахтай холбогдон захиалагч, гүйцэтгэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.

2. Захиалагч нь [гэрээний нэр, дугаар]-г (цаашид “ажил” гэх) [гэрээний үнийг тоогоор болон үсгээр] (цаашид “гэрээний үнэ” гэх) гүйцэтгэхээр ирүүлсэн гүйцэтгэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ буюу ажлын нийт төсөвт өртөг нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.

3. Гэрээний нийт дүн: _____ төгрөг. Үүнээс: /Аль тохирохыг нь бөглөнө, бусдыг нь устгана/

Улсын төсвэөс: 20.... онд: _____ төгрөг; 20.... онд: _____ төгрөг;

Орон нутгийн төсвэөс: 20.... онд: _____ төгрөг; 20.... онд: _____ төгрөг;

Өөрийн хөрөнгө: 20.... онд: _____ төгрөг; 20.... онд: _____ төгрөг.

4. Гүйцэтгэгч нь _____ байршилтай _____ хүчин чадал бүхий _____ ам.метр талбай / _____ шоо метр эзлэхүүн/-тай, _____ суурь, _____ хана, _____ хүчилттай, _____ давхар _____ барилга угсралт /барилгын засвар, тоног төхөөрөмж сууринуулах/-ын ажлыг _____ инженерийн шугам сүлжээ /дулаан, цахилгаан, цэвэр, бохир усан хангамж/, _____ туслах барилга /бусад ажил/-ын хамт _____ оны _____ дугаар сарын _____ -ны өдөр эхэлж, _____ оны _____ дугаар сарын _____ -ны өдөр ашиглалтад оруулна.

5. Дор дурдсан баримт бичиг нь гэрээний салшгүй хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:

- 5.1. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;
- 5.2. Бусад шаардлагатай баримт бичиг ;
- 5.3. Үнийн санал
- 5.4. Гэрээний тусгай нөхцөл;

- 5.5.** Гэрээний ерөнхий нөхцөл;
- 5.6.** Техникийн тодорхойлолт;
- 5.7.** Зураг;
- 5.8.** Гүйцтгэгчийн ирүүлсэн үе шатны ажлын хуваарь :
- 5.9.** Санхүүжилтийн хуваарь;
- 5.10.** Ажил гүйцэтгэх хуваарь.

Гэрээ нь энд дурдсан ажлыг гүйцэтгэх талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний бичиг баримтууд хоорондоо зөрчилдвэл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

6. Захиалагч, гүйцэтгэгч нь гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлд заасан эрх, үүрэг хүлээнэ.

7. Гүйцэтгэгч нь гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан ажлыг гүйцэтгэж, зөрчил, гологдол арилгах үүрэг хүлээнэ.

8. Захиалагч нь гэрээний дагуу гүйцэтгэгчийн хийх ажил болон зөрчил, гологдол арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний төлбөрийг гүйцэтгэгчид төлөх үүрэг, хүлээнэ.

9. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр болон утсан холбоогоор харилцана.

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]

[Гарын үсэг]

ТАМГА

[Захиалагчийн хаяг]

[Утас/факсын дугаар]

[Харилцагч банкны нэр, дансны дугаар]

ГҮЙЦЭТГЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]

[Гарын үсэг]

ТАМГА

[Захиалагчийн хаяг]

[Утас/факсын дугаар]

[Харилцагч банкны нэр, дансны дугаар]